

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2021 оны ... дугаар
сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийг үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагад болон айл өрхийн цахилгаан түгээх сүлжээнээс худалдан авсан цахилгааны төлбөрөөс суутган тооцож ажиллахыг цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Г.Эрхэмбаяр/-нд даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

**Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс
түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгааны тариф**

Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) дараах байдлаар тогтооно.

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Өдрийн цагаар /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	140.18
2	Оргил ачааллын үед буюу оройн цагаар /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	221.89

---oOo---